



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№185 /395/

2022.10.14

Цаг үе, үйл явдал

ХУУЛИЙН ОФИЦЕРУУД НОМЫН ДУУ СОНСЛОО

Зэвсэгт хүчний Жанжин штаб, АНУ-ын Батлан хамгаалахын Олон Улсын эрх зүй судлалын институттэй хамтран "Хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн тухай хууль" сэдвийн хүрээнд нэгтгэл, ангиудын хуулийн офицеруудад эрчимжүүлсэн сургалтыг зохион байгууллаа.

Батлан хамгаалахын олон улсын эрх зүй судлалын институтын дарга хурандаа Иан Векслер, дэд хурандаа Жон Черри, дэд хурандаа Карл Мюллер Дээд болон давж заалдах шатны шүүхийн өмгөөлөгч ахмад Түмэнтөгс Армстронг тэргүүтэй зочин багш нар ажиллав. Хоёр улсын батлан хамгаалах салбарын офицерууд харилцан туршлага солилцох зорилго бүхий цаашид олон улсын харилцаанд өндөр ач холбогдолтой энэхүү сургалтын төгсгөлд оролцогч бүрэлдэхүүнд гэрчилгээ гардуулсан юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
5	-9


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.415.00	3.430.0
EUR	3.335.0	3.350.0
CNY	476	480
RUB	51.20	51.80
JPY	23.70	24.20
KRW	2.43	2.47

ЗУРХАЙ



2022.10.10 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 20

АВЛИГА БОЛ ТУСГААР ТОГТНОЛ, ХӨГЖЛИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ МӨН



"Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Ганзориг илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэх хэлбэрээр явууллаа.

Сургалтаар авлига, ашиг сонирхлын талаар хууль, эрх зүйн орчин, тэдгээрийн тухай ойлголт, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны эрхийн хязгаарлалт, ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар

төрийн байгууллагын хүлээ нийтлэг үүрэг, эрх бүхий албан тушаалтнуудын эрх, үүрэг, хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудлуудын талаар мэдээ мэдээлэл өгч, "Үндсэн хууль"-ийн эмхэтгэл, сургалтын материал, авлигын эсрэг тараах хуудас зэргийг анги салбар бүрийн төлөөлөлд гардуулсан юм.

Монгол Улсын Авлигын эсрэг тухай хуулийн 3.11-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх

аливаа эрх зүйн зөрчлийг авлига гэнэ хэмээсэн байдаг. Нийгмийн хөгжлийн шударга, эрүүл чиг хандлагыг улс эх орондоо, аймаг сумд, ажил алба, өөрийн хүрээлэл дундаа бий болгож, хэвшүүлэхэд иргэн таны оролцоо чухал бөгөөд төрийн албан тушаалтан, алба хаагчдаас аливаа хууль бус үйлдэл хүсэхгүй, шаардахгүй, авлигал өгөхгүй, авахгүй байх ёстой.

Түүнчлэн НҮБ-ын Бодлогын баримт бичигт Төрийн эрх мэдэл, эрх хэмжээ, албан тушаалаа хувийн ашиг сонирхолд ашиглах явдлыг хэлнэ гэж тусгасан байдаг аж.

Х.УНДАРМАА

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ЦАГААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.10-18.07

Барилдлага:

Шид

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Төрөн түгэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр аливаа үйлс сэтгэлчлэн бүтнэ. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

"УЛААНХУАРАНГИЙН ТЭМДЭГЛЭЛҮҮД" НОМЫН НЭЭЛТ БОЛЛОО



ЦДБЭЧ-ын түүхт найруулагч, Монголын 90 жилийн ойд зориулан телевизүүдийн "Алтан шонхор" бүтээгдсэн "Улаанхуарангийн тэмдэглэлүүд" номын нээлт өчигдөр ЦДБЭЧ-ын "Соёмбо" С.Болд энэхүү номондоо танхимд боллоо.

Эл номын зохиогч, айлын тулгын чулуу, бахдам ЦДБЭЧ-ын ахмад уран бүтээлч, гавьяаг өргөсөн олон арван

уран бүтээлчийн дурьдатгал, дурсамж, бүтээл туурвилын өрнүүн түүхийг баримтжуулан өгүүлжээ.

Түүнчлэн цэргийн чуулгын сүүлийн жилүүдэд хийж хэрэгжүүлсэн урлаг соёлын арга хэмжээнүүд

уран бүтээлчдийн амжилтыг толилуулсан байна. Тус номын ерөнхий редактораар ЦДБЭЧ-ын Сургалт, соёл, хүмүүжил маркетингийн албаны дарга дэд хурандаа Р.Өнөржаргал ажиллажээ.

Ө.НАСАНТОГТОХ



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 628,929,009

Эдгэрсэн

Нийт: 607,994,808

Нас барсан

Нийт: 6,568,219

Сурвалжилга

Б.ЭНХЗОРГОЛ:ЗАЛУУЧУУД МААНЬ ЦЭРЭГТ ИРЭХДЭЭ ХУВЬ ХҮН, ЦЭРГИЙН АЛБА ХААСНЫ ДАРААГААР БИЕ ХҮН БОЛЖ ТӨЛӨВШСӨН БАЙДАГ



Өсвөр үеийнхэнд цэрэг, эх оронч хүмүүжил олгох, цэргийн албыг сурталчлах, ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ҮБХИС-иас “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгууллаа.

Эл өдөрлөгт ҮБХИС-ийн Сургалт, цэргийн алба хариуцсан дэд захирал хурандаа Б.Энхзоргол тэргүүтэй удирдлагын бүрэлдэхүүн, алба хаагчид, Аюулгүй байдлын дээд сургуулийн сонсогчид, “Тэмүүжин-Өрлөг” болон Нийслэлийн ЕБ-ын 41, 53 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчид, эцэг эхийн төлөөлөл

оролцов.

Энэ үеэр ҮБХИС-ийн түүхэн замнал, хугацаат цэргийн алба хаах орчин нөхцөл, Харуул үйлчилгээний ротын үйл ажиллагааг сурагч, эцэг эхчүүдэд танилцуулсан юм. Мөн Зэвсэгт хүчний 029 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагчид нэг жилийн хугацаанд олж авсан бие бялдрын өв тэгш хүмүүжил, сэтгэл зүй, мэдлэг ур чадвар, жагсаалч байдлаа гайхуулахын зэрэгцээ, цэргийн дүрмийн дагуу харуулын үүргээ хэрхэн биелүүлдэг талаарх үзүүлэх тоглолтоо толилуулав. Үүний дараа эцэг эх, сурагчид

хугацаат цэргийн алба хаагчдын амьдралын орчин нөхцөлтэй танилцсан юм.

ҮБХИС-ийн Сургалт, цэргийн алба хариуцсан дэд захирал хурандаа Б.Энхзоргол энэ үеэр “Манай хугацаат цэргийн алба хаагчид модон морин дээгүүр харайх, гийр өргөх, турник, жагсаалын үзүүлэх тоглолтуудыг маш олон төрлөөр хийж гүйцэтгэлээ. Эдгээрээс цэргийн алба хаагч нэг жилийн хугацаанд сэтгэл зүй болоод бие бялдрын хувьд хэрхэн бэлтгэгдэж, хатуужиж чадсаныг харж болно. Залуучууд маань цэрэгт

ирэхдээ хувь хүн, цэргийн алба хаасны дараагаар бие хүн болж төлөвшсөн байдаг. Бие хүн гэдэг нь эх оронч үзэл, хүмүүжилтэй, бие бялдрын хувьд эрүүл, зан авирын хувьд төлөвшсөн хүнийг хэлдэг. Сая та бүхний харсанчлан тус өдөрлөг нь цэргийн албыг сурталчлах гэхээсээ илүү бодит нөхцөл байдлыг үнэн мөнөнөөр нь харуулах зорилготой юм” хэмээсэн юм.

Харин Нийслэлийн ЕБ-ын 53 дугаар сургуулийн сурагч Б.Өсөхбаяр “ҮБХИС-иас зохион байгуулж байгаа “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцохоор

зорьж ирлээ. Эр хүн болоод ч тэр үү цэргийн хүн харахаар эмх цэгц, хүч чадал, дүрэм журам, сүр жавхааг мэдэрдэг. Миний хувьд хэдий ахлах ангийн сурагч ч ирээдүйд ямар мэргэжилтэй хүн болохоо хараахан шийдэж чадаагүй байна. Өөрөө цэргийн амьдралд сонирхолтой болохоор энэ завшааныг ашиглаад ҮБХИС-тай танилцаж байна. Маш сайхан санагдлаа. Бид бүхэнд зориулан тус арга хэмжээг зохион байгуулж буй ҮБХИС-ийн ах эгч нартаа маш их баярлалаа” гэсэн юм.

Ө.НАСАНТОГТОХ

МОНГОЛ УЛСЫН ЗХЖШ-ЫН ҮЛГЭР ЖИШЭЭ ҮЛЭЭВЭР НАЙРАЛ ХӨГЖМИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН “ДЭЛХИЙН ЦЭРГИЙН СОЁЛЫН НААДАМ”-Д ОРОЛЦОЖ БАЙНА



БНСУ-ын Өмнөд Чуннам муж, Герюн хот, Батлан хамгаалах яам, Нэгдсэн хүчний Хуурай замын хүчнээс хамтран зохион байгуулж буй “Дэлхийн цэргийн соёлын наадам-2022” арга хэмжээ 2022 оны 10 дугаар сарын 7-ноос 23-ны өдрүүдэд Герюн хотод зохион байгуулагдаж байна.

Тус арга хэмжээнд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс ЗХЖШ-ын харьяа

Үлгэр жишээ, үлээвэр найрал хөгжмийн уран бүтээлчдийн баг оролцож байгаа бол АНУ, БНСУ, ИБУИНХУ, Вьетнам, Тайланд, Франц, Индонез, Малайз зэрэг улсын цэргийн хөгжмийн багууд мөн оролцож байна.

Иргэн-цэргийн бэхжүүлэх, цэргийн хамтын ажиллагаа, цэргийн итгэлцлийг нэмэгдүүлэх зорилготой тус наадмын үеэр БНСУ-ын Нэгдсэн хүчин болон БНСУ-д

байрлаж буй АНУ-ын хүчний зарим техник, хэрэгслийг дэлгэн танилцуулж, Солонгосын агаарын цэргийн хүчний Black eagles баг агаарын үзүүлбэр үзүүлж байна.

ЗХЖШ-ын харьяа Үлгэр жишээ, үлээвэр найрал хөгжмийн багийн тоглолт дараах хуваарьтай байгаа бөгөөд БНСУ-д оршин сууж буй иргэд Та бүхэн арга хэмжээнд оролцож, тоглолтыг үзэж, сонирхохыг

урьж байна.

ТОГЛОЛТЫН ХУВААРЬ
10 дугаар сарын 15-22-ны өдрийг хүртэл өдөр бүр
11:30 Талбайд жагсах
13:30 Төв талбайд тоглолт
15:30 Жагсаалын үзүүлбэр
10 дугаар сарын 23-ны өдөр
15:00-16:45 Хаалтын ажиллагаа, БНСУ-ын Цэргийн хөгжмийн багтай хамтарсан тоглолт

Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яам

ЗЭВСЭГТ ХҮЧИН, АНГИ, БАЙГУУЛЛАГАА СУРТАЛЧИЛЛАА



Зэвсэгт хүчин болон ангийн үйл ажиллагааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр сурталчлан иргэд, залуучууд, өсвөр үеийнхэнд эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн-

байлдагч Х.Алтанбагана “Зэвсэгт хүчний нүүр царай болсон 98 жилийн түүхэн алдар гавьяатай Зэвсэгт хүчний 032 дугаар ангидаа цэргийн алба хаасандаа үргэлж бахархах болно. Цэргийн албанд сурсан мэдсэн зүйлээ туулж өнгөрүүлэх амьдралынхаа тулгуур нь болгож, зөв сэтгэлгээтэй, гэгээлэг үйлстэй, эх орныхоо төлөө үнэнч шударгаар хөдөлмөрлөсөн иргэн байна” хэмээв.

Нэвтрүүлэг 2022 оны 10 дугаар сарын 17-ны “Даваа” гарагийн 21.00 цагт МҮОНТ-ээр үзэгч олны хүртээл болно.

АХМАД Т.ДЭЛГЭРМАА

“ХАЛАГДАХ ЦЭРГИЙН ВАЛЬС” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 110 дугаар ангид 2021 онд татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдын дунд “Халагдах цэргийн вальс” арга хэмжээг Орхон аймгийн Говил багийн “Эгшиглэн” соёлын төвтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлжээ.

Энэ үеэр хугацаат цэргийн алба хаагчдын дунд урлагийн номер, хөгжөөнт тэмцээн, азтан шалгаруулах уралдааныг зохион байгуулж шилдгээ тодруулсан аж.

Мөн үйл ажиллагааны төсгөлд эмэгтэйчүүдийн зөвлөлөөс давсаар хийсэн гар урлан бүтээл болох шар шувуу, сахиусан тэнгэрийг гэрэл зургийн хамт хугацаат цэргийн алба хаагчдад бэлэг болгон өгөв.

АХЛАГЧ Б.ОДГЭРЭЛ

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №05

5. НУМ
Хагас дугуй хэлбэрийн зүйлийг нум гэдэг. Нум сумны нум, машин тэрэгний нум, хүний хөлийн дотор талын дугуйрсан хэсэг буюу нум. Монгол бичигт, үгийн адарт орсон И, мөн О, У, Ө, Ү эгшиг болон Ба, Ка, Па, Фа, Ха, Га, их инхлэг зэрэг гийгүүлэгчийн бүтцэд нуман зурлага ордог. Нумыг бичихдээ, эхлээд нуруун дээрээс богино шилбэ татаад, үзгээ салган, анх эхэлсэн үзүүр хэсгээс нь нар зөв эргэсэн хагас дугуй зураас татаж нийлүүлэн гүйцээдэг. Үгийн төгсгөлд орох нумыг үзгээ салгалгүй бичдэг. Хоёр нум дараалж ороход эхнийхийг арай бага, хоёрдохыг үндсэн хэмжээгээр нь бичнэ.

Дармалаар: Бичмэлээр:

